

**СЭДЭВ 13:**

МОНГОЛБАНКНЫ

**АЛТ**

ХУДАЛДАН АВАЛТ

## МОНГОЛБАНК ЯМАР ЗОРИЛГООР АЛТ ХУДАЛДАН АВДАГ ВЭ?

Гадаад валютын улсын албан нөөцийг нэмэгдүүлэх дотоодын эх үүсвэрүүдийн нэг нь алт худалдан авалт юм.

Монголбанк дотоодын алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс худалдан авсан алтыг гадаадын байгууллагуудад олон улсын жишигт хүргэн цэвэршүүлэн мөнгөжүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлдэг.



## МОНГОЛБАНКНЫ АЛТ ХУДАЛДАН АВАЛТЫН СТАТИСТИК ХЭДЭД ХҮРСЭН БЭ?

2014 онд Монголбанк 79 аж ахуйн нэгж, 105 иргэнээс нийт 12.7 тонн алтыг 830.8 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оноос 6.7 тонн буюу 2 дахин өссөн үзүүлэлт юм.

Монголбанкны Эрдэнэсийн санд 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 2,018.6 кг алтны үлдэгдэлтэй байсан ба 2015 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанк давхардсан тоогоор 1587 аж ахуйн нэгж байгууллага, 1723 иргэнээс нийт бохир жингээр 12,870.7 кг алт худалдан авсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 20 хувиар өссөн тооцоо гарч байна.



## МОНГОЛБАНКНЫ АЛТ ХУДАЛДАН АВАЛТ НЭМЭГДСЭН ШАЛТГААН ЮУ ВЭ?

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан “Монголбанк түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 2.5 хувь, нэмэлт төлбөрийн хэмжээг 0 хувьтай тэнцүү” байхаар зааж 2014 оны 01 дүгээс сарын 24–ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Уг өөрчлөлт орсонтой холбоотойгоор Монголбанкинд иргэдийн тушааж буй алтны хэмжээ эрс өссөн.




## АЖ АХУЙН НЭГЖ НИЙТ АЛТ ТУШААЛТЫН ХЭДЭН ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙНА ВЭ?

2015 оны эхний 10 сарын байдлаар нийт худалдан авсан алтны 53.8 хувийг буюу 6,925.1 кг алтыг аж ахуйн нэгж, байгууллагаас, үлдсэн 46.2 хувь буюу 5,945.6 кг алтыг иргэдээс худалдан авсан байна.



## 2015 ОНД ХУДАЛДАН АВСАН АЛТНЫ ХЭМЖЭЭ ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦИЙН ЯМАР ХЭСГИЙГ БҮРДҮҮЛСЭН БЭ?

2015 онд 12 удаагийн ачилтаар нийт бохир жингээр 10,9 тонн (цэвэр жингээр 289.1 мянган унци) алтыг экспортлосон байна. Энэ нь 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ханшаар тооцоход ойролцоогоор 311.1 сая ам.доллараар валютын нөөцийг бүрдүүлсэн тооцоо гарч байна.



Эх сурвалж: Монголбанк